



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 4/115

Булган сум

Хэлний бодлогын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх 66.1 дэх заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг хөгжүүлэх, хамгаалах үндсэн үүрэг бүхий “Хэлний бодлогын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. “Хэлний бодлогын салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарч байгаатай холбогдуулан 2024 оны А/748 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025. оны
02. дугаар сарын 19. ны/ний өдрийн 4/115.. дүгээр
захирамжийн хавсралт



ХЭЛНИЙ БОДЛОГЫН ОРОН ТООНЫ БУС САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа,
удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн дарга

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Насан туршийн суралцахуйн төвийн захирал

1 дүгээр сургуулийн Монгол хэлний багш нарын

төлөөлөл

1 дүгээр сургуулийн Монгол хэлний багш нарын

төлөөлөл

2 дугаар сургуулийн Монгол хэлний багш нарын

төлөөлөл

3 дугаар сургуулийн Монгол хэлний багш нарын

Төлөөлөл

Монгол хэлний ахмад багш нарын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн

бодлогын хэлтсийн Боловсролын бодлого хариуцсан
мэргэжилтэн